



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/241

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нийгэм, эдийн засаг болон шилжилт хөдөлгөөний системийн динамик загвар боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний зардалд 20.000.000 (Хорин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. “Нийгэм, эдийн засаг болон шилжилт хөдөлгөөний системийн динамик загвар боловсруулах” ажлын зөвлөх үйлчилгээний зардлын 20.000.000 (Хорин сая) төгрөгийг “Засаг дарга данс”-ны хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал (Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх) зардлаас санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажлын хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтыг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН